

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: **ӨВА-2025/001/НА-СТА-ЗГТС**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2025 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Аудитор: Р.Цэрэндолгор

Утас: 70323108 Цахим хаяг: Tserendolgor@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.	9
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 32 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн.	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. Аудитын илрүүлэлт	12
5.1 Төлбөрийн акт	13
Байхгүй болно.....	13
5.2 Албан шаардлага	13
Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, мэдээ тайлан, баримт бичгийг ирүүлээгүй, тэтгэврийн даатгалын сан 179,180.5 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	13
Шийдвэрлэсэн нь:	13
5.3 Зөвлөмж	13
Байхгүй болно.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 136
танай _____-ны № _____-г

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Н.НОРГИНБАДАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн даатгалын санд тайлант онд ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 1,649.5 сая төгрөг, ҮОМҮӨ-ний даатгалын сангийн орлого 2,494.3 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 5,158.1 сая төгрөг, тэтгэврийн даатгалын сангийн орлого 49,754.3 сая төгрөг нийт сангийн орлого 59,056.2 сая төгрөг байна.

Сангийн зарцуулалтыг үзэхэд ажилгүйдлийн даатгалын сан, ҮОМШӨ-ний даатгалын сан, тэтгэмжийн даатгалын сан, тэтгэврийн даатгалын сангуудын нийт зарлага 171,422.3 сая төгрөг байна.

Тайлант онд нийгмийн даатгалын системийн хэмжээнд программ хөгжүүлэлттэй холбоотой жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацааг хоцроож ирүүлсэн.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

D:\Auditin gazar\baiguullagiiin dotood barimt\A4

2025.03.25

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,514,025,654.79	17,408,372,653.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,171,816,390.26	14,808,114,977.17
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	13,171,816,390.26	14,808,114,977.17
31210	Төгрөг	13,171,816,390.26	14,808,114,977.17
31211	Төрийн сангийн харилцах	426,306.04	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	13,171,390,084.22	14,808,114,977.17
33	АВЛАГА	2,342,209,264.53	2,600,257,675.91
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	450,294,833.55	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,793,685,952.23	1,794,811,876.23
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.00	698,921,445.25
33500	Бусад авлага	98,228,478.75	106,524,354.43
33510	Байгууллагаас авах авлага	98,228,478.75	3,954,081.76
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	102,570,272.67
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,514,025,654.79	17,408,372,653.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	836,754,596.21	1,905,876,874.57
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	836,754,596.21	1,905,876,874.57
41300	Өглөг	94,443,813.36	483,445,208.62
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	94,443,813.36	0.00
41360	Бусад өглөг	0.00	483,445,208.62
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	140,010,863.36
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	340,622,962.43
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0.00	2,811,382.83
41400	Урьдчилж орсон орлого	742,310,782.85	1,422,431,665.95
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	742,310,782.85	1,422,431,665.95
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,677,271,058.58	15,502,495,778.51
51	Засгийн газрын хувь оролцоо	14,677,271,058.58	15,502,495,778.51
51200	Хуримтлагдсан үр дүн	14,677,271,058.58	15,565,364,543.46
51210	Өмнөх үеийн үр дүн	16,768,802,221.71	14,677,271,058.58
51220	Тайлант үеийн үр дүн	-2,091,531,163.13	888,093,484.88
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.00	-62,868,764.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,514,025,654.79	17,408,372,653.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	226,686,183,979.56	232,182,142,663.34
11	ТАТВАРЫН ОРЛОГО	51,451,190,624.76	59,056,226,569.28
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	51,451,190,624.76	59,056,226,569.28
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	36,091,972,583.48	49,754,265,809.21
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,737,989,765.07	5,158,119,165.02
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,367,583,945.79	2,494,309,493.51
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	678,158,977.77	1,649,532,101.54

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,575,485,352.65	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	261,622,097.74	200,843,726.03
120	Нийтлэг татварын бус орлого	261,622,097.74	200,843,726.03
120002	Хүүгийн орлого	66,122,349.24	75,754,215.00
120003	Торгуулийн орлого	0.00	83,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	102,752,205.50	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102,752,205.50	0.00
120009	Бусад орлого	92,747,543.00	125,006,111.03
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	174,973,371,257.06	172,925,072,368.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,687,033,400.00	32,772,479,335.03
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,687,033,400.00	32,772,479,335.03
1330	Төсвийн захирагчдаас	159,286,337,857.06	140,152,593,033.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	159,286,337,857.06	140,152,593,033.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	228,777,715,142.69	231,294,049,178.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	228,777,715,142.69	231,294,049,178.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,197,890.00	26,985,840.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,197,890.00	13,502,390.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,515,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,197,890.00	11,987,390.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	13,483,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	13,483,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,767,517,252.69	231,267,063,338.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,563,574,197.00	171,422,340,731.33
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	135,563,574,197.00	171,422,340,731.33
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	93,203,943,055.69	59,844,722,607.13
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	93,203,943,055.69	59,844,722,607.13
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-2,091,531,163.13	888,093,484.88
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,091,531,163.13	888,093,484.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	230,439,672,147.41	243,138,394,148.77
11	ТАТВАРЫН ОРЛОГО	51,450,014,636.64	70,490,175,187.45
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	51,450,014,636.64	70,490,175,187.45
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	36,112,179,576.16	50,869,365,150.56

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,732,769,039.09	5,146,997,178.91
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,363,077,733.68	2,591,153,906.94
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	676,209,146.94	1,670,334,017.00
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,565,779,140.77	10,212,324,934.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	310,315,253.71	209,960,528.32
120	Нийтлэг татварын бус орлого	310,315,253.71	209,960,528.32
120002	Хүүгийн орлого	57,572,810.45	75,811,192.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	252,742,443.26	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	252,742,443.26	0.00
120009	Бусад орлого	0.00	134,149,336.32
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	178,679,342,257.06	172,438,258,433.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	19,393,004,400.00	32,285,665,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19,393,004,400.00	32,285,665,400.00
1330	Төсвийн захирагчдаас	159,286,337,857.06	140,152,593,033.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	159,286,337,857.06	140,152,593,033.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	228,899,536,996.29	241,502,095,561.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	228,899,536,996.29	241,502,095,561.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,197,890.00	43,655,703.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,197,890.00	13,502,390.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,515,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,197,890.00	11,987,390.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	30,153,313.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	30,153,313.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,889,339,106.29	241,458,439,858.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,685,396,050.60	171,131,739,303.52
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	135,480,094,625.00	171,131,739,303.52
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	205,301,425.60	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	93,203,943,055.69	70,326,700,555.24
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	93,203,943,055.69	70,326,700,555.24
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,540,135,151.12	1,636,298,586.91
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,540,135,151.12	1,636,298,586.91
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,631,681,239.14	13,171,816,390.26
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,171,816,390.26	14,808,114,977.17

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,768,802,221.71	16,768,802,221.71
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,768,802,221.71	16,768,802,221.71
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	-2,091,531,163.13	-2,091,531,163.13
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,677,271,058.58	14,677,271,058.58
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	14,677,271,058.58	14,677,271,058.58
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-62,868,764.95	-62,868,764.95
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,614,402,293.63	14,614,402,293.63
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	888,093,484.88	888,093,484.88
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	15,502,495,778.51	15,502,495,778.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	175,588,085,000.00	171,145,241,693.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	175,588,085,000.00	171,145,241,693.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,513,200.00	13,502,390.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,513,200.00	13,502,390.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,903,300.00	1,515,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	13,609,900.00	11,987,390.00

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	175,563,571,800.00	171,131,739,303.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	175,563,571,800.00	171,131,739,303.52
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	175,563,571,800.00	171,131,739,303.52
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	175,588,085,000.00	92,751,243,423.43
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,285,665,400.00	32,285,665,400.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	32,285,665,400.00	32,285,665,400.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	143,302,419,600.00	60,465,578,023.43
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	143,302,419,600.00	60,465,578,023.43
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын сан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулна” гэж заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг байна.

Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн, хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг даатгуулагчид хүргэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ боловсруулан ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын сан нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын сан нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,171,816.4	14,808,115.0	1,636,298.6
Авлага	2,342,209.3	2,600,257.7	258,048.4
Нийт хөрөнгө	15,514,025.7	17,408,372.7	1,894,347.0
Өр төлбөр	836,754.6	1,905,876.9	1,069,122.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,677,271.1	15,502,495.8	825,224.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	15,514,025.7	17,408,372.7	1,894,347.0

Тайлант хугацаанд 1,636.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, авлага, өр төлбөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 175,588.1 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 56,179.3 сая төгрөг төлөвлөснөөс 59,901.0 сая төгрөгийн орлого төвлөрч, гүйцэтгэл 106.6 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт

1	Тэтгэврийн даатгалын сан	48,609.4	49,754.3	-1,144.9	102.4
2	Тэтгэмжийн даатгалын сан	4,163.8	5,158.1	-994.3	123.9
3	Ажилгүйдлийн даатгалын сан	1,352.5	2,494.3	-1,141.8	184.4
4	ҮОМШӨ	2,053.6	2,494.3	-440.7	121.5
	Нийт дүн	56,179.3	59,901.0	-3,721.7	106.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллагад хэрэгжсэн төсөл арга хэмжээ байхгүй.

4.Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Р.Цэрэндолгор гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитын менежер П.Хорлоосүрэн, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг нийгмийн даатгалын системийн хэмжээнд программ хөгжүүлэлттэй холбоотой Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацааг хоцроож 2025 оны 03 дугаар сарын 17-нд баталгаажуулж ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 70 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын дүн 231,317.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2,313.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 32 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай гэж үнэлсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд нийгмийн даатгалын системийн хэмжээнд программ хөгжүүлэлттэй холбоотой жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацааг хоцроож 2025 оны 03 дугаар сарын 17-нд ирүүлсэн.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй болно.

5.2 Албан шаардлага

Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, мэдээ тайлан, баримт бичгийг ирүүлээгүй, тэтгэврийн даатгалын сан 179,180.5 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Байхгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алдаа гараагүй												
Дүн	0	0	0	0	0	0	0	0	00	00	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, мэдээ тайлан, баримт бичгийг ирүүлээгүй, тэтгэврийн даатгалын сан 179,180.5 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	1	179,180.5			1	179,180.5						

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дүн	1	179,180.5	0	0	1	179,180.5			00	0	0
-----	---	-----------	---	---	---	-----------	--	--	----	---	---

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн	0	0	0	0	00	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Нийт дүн	0	0	0	0	00	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

